МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/19. Мандалговь

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Улсын Их хурлын 2009 оны 33-р тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2020 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас 2019 онд чөлөөлөгдсөн иргэдийн нэрсийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, 2020 онд чөлөөлөгдсөн иргэдийн нэрсийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Хоёр. Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлийн 3-д зааснаар мөнгөн төлбөр орлуулан хаах, хаахаас чөлөөлөгдсөн иргэдийг цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр тоо бүртгэлд бүртгэн авч цаашид Цэргийн штабын "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу цэргийн анхан шатны сургалтад хамруулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481219 35